

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 72 дугаар тогтоолд төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байхаар тус тус заасан.

Гэвч Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газар тусгагдаагүй орхигдсон байна.

Практик шаардлага

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо өссөн бөгөөд 2010 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч 1 байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болсон байна.

Мөн хууль батлагдаж байх үед төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ 14.8 сая тонн байсан бол 2023 оны байдлаар 36.1 сая тонн болж **2.4 дахин** нэмэгдсэн, салбарт нийт 15000 орчим хүн 1115 км замыг хариуцан ажиллаж байсан бол ойрын үед хэрэгжихээр шийдвэр гарсан төмөр замуудтай нийлээд сүлжээний нийт урт 4200 км орчим болж **3.7 дахин**, энэ хэрээр ажиллах хүч 50000 орчим болж **3.3 дахин** тус тус нэмэгдэх тооцоо гарч байна.

Иймд өсөн нэмэгдсээр байгаа тээврийн хэрэгцээг хангах, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх, тээврийн сүлжээг өргөжүүлэх, төмөр замын чиглэлийн судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, технологи, инновацийг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төмөр замын салбарт мөрдөх стандартыг боловсронгуй болгох, төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогч өмчийн олон хэлбэрийн хуулийн этгээдийн зах зээлийн өрсөлдөөний тэгш байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, бизнесийн эрх зүйн орчныг сайжруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэдлэг чадвартай хүний нөөц бүхий төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулах зүй ёсны шаардлага тулгараад байна.

Үйл ажиллагааны чиглэл

Төмөр замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг буюу Төмөр замын газар” нь дараах чиг үүргийн дагуу ажиллана. Үүнд:

1. Төмөр замын тээврийн хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт боловсруулах, батлах, сурталчлах;

2. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг болон нэгдсэн технологийн горим батлах, суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулах, төмөр замын суурь бүтэц хооронд дамжуулах ачааны төрөл, хэмжээг тогтоох, хяналт тавих;

3. Төмөр замын тээврийн тариф, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хооронд байгуулсан гэрээг хянаж, санал, дүгнэлт гаргах, хэрэгжилтийг хангуулах;

4. Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг хангуулах;

5. Төмөр замын тээврийн салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох;

6. Төмөр замын тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

7. Төмөр замын суурь бүтэц, салбар зам, барилга байгууламжийг барих, өргөтгөх ажилд хяналт тавих, тэдгээрийн хувийн хэргийг хөтлөх;

8. Хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, гэрчилгээжүүлэх;

9. Төмөр замын тээврийн статистик, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

10. Төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах, мэргэжлийн шинжээчийн эрх олгох зэрэг үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах.

Бүтэц зохион байгуулалт, санхүүжилт

Төмөр замын газрын бүтцийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд төмөр замын чиглэлээр хуульд заасан төрийн зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээг нээлттэй, хүртээмжтэй, ил тод байлгах, төрийн захиргааны бусад байгууллагатай чиг үүргийн давхцалгүй байх, цомхон чадварлаг байх зэрэг суурь зарчимд нийцүүлэн ажлын байрны шинжилгээ, чиг үүргийн хуваарилалтыг боловсруулсан.

Засгийн газрын 2012 оны 91 дүгээр тогтоолоор байгуулсан “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын чиг үүрэг Төмөр замын тээврийн тухай хуулийн дагуу Төмөр замын газарт шилжих тул тус төвийг татан буулгаж 25 орон тоо, Зам, тээврийн яамнаас 13 орон тоог Төмөр замын газарт шилжүүлэн 2025 онд 38 албан хаагчтай ажиллуулахаар төлөвлөсөн болно.

Улсын төсөвт дарамт үзүүлэхгүй байх зорилгоор албан хаагчдын цалингийн шатлал зэрэг дэвийг Засгийн газрын 2022 оны 487, 2023 оны 240, 241 дүгээр тогтоолуудыг үндэслэн төлөвлөж, төсвийн тооцоог Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар”-ын хүрээнд 1.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР